

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Цахим системд нийтэлсэн огноо: 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр
Бүртгэлийн дугаар: НХААГ/202208574

1. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтад “Хотын нийтийн тээврийг шинэчлэх болон тулгуурт гүүрэн байгууламж бүхий багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх төсөл” арга хэмжээ тусгагдаж, улмаар 2022 онд багтаан эхлүүлэх тухай Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 31 дүгээр тэмдэглэл, мөн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай Засгийн газрын 2022 оны 226 дугаар тогтоол тус тус гарсан. Энэхүү төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр Нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан ба НИТХ-ын 2022 оны “Нийслэлийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 65 дугаар тогтоолоор нэршил болон төсөвт өөрчлөлт оруулж, тогтоолын хоёрдугаар хавсралтаар “Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Улаанбаатар хотод хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил” (цаашид “төсөл” гэх) нэршилтэйгээр холбогдох эх үүсвэр нь батлагдсан.
Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/959 дүгээр захирамжаар “Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт” ХХК-д дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлсэн. Мөн Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар дэмжигдсэн “Тулгуурт гүүрэн байгууламж бүхий Улаанбаатар хөнгөн галт тэрэгний нэгдүгээр шугам”-ын техник эдийн засгийн үндэслэл 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдөр захиалагчид шилжиж ирсэн.
Иймд дээр дурдсан шийдвэр болон тогтоол, захирамжийн дагуу “Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт” ХХК нь “Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Улаанбаатар хотод хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил” буюу “Тулгуурт гүүрэн байгууламж бүхий Улаанбаатар хөнгөн галт тэрэгний нэгдүгээр шугамын суурь бүтцийн техникийн зураг төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээг 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр зарласан боловч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан хураангуй жагсаалт үүсээгүй тул тус зөвлөх үйлчилгээг үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг үүгээр дахин урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Тулгуурт гүүрэн байгууламж бүхий Улаанбаатар хөнгөн галт тэрэгний нэгдүгээр шугамын суурь бүтцийн техникийн зураг төсөл боловсруулах, түүнд шаардлагатай инженер-хайгуулын судалгаа, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, барилга угсралтын ажлын нийт төсвийн тооцоолол хийх ажлуудаас бүрдэнэ. Зөвлөх үйлчилгээ нь цаашид Тулгуурт гүүрэн байгууламж бүхий Улаанбаатар хөнгөн галт тэрэгний нэгдүгээр шугамын дээд бүтцийн техникийн зураг төсөл боловсруулах ажлаар үргэлжилнэ.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримтыг баталгаажуулж ирүүлнэ. Үүнд:
 - 3.1. Компаний танилцуулга, голлох болон инженер техникийн ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - 3.2. Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг ирүүлэх бөгөөд үйл ажиллагааны чиглэл нь зураг төсөл боловсруулах болон хийгдэх гэж буй ажилтай холбоотой байх;
 - 3.3. Төмөр замын зураг төсөл боловсруулах, Гүүр хоолойн зураг төсөл боловсруулах, Барилгын зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл болон холбогдох бусад тусгай зөвшөөрлийн хуулбар;
 - 3.4. Сүүлийн 3 жил буюу 2019, 2020, 2021 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт;
 - 3.5. Сүүлийн 3 жилийн (2019, 2020, 2021 он) аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна;
 - 3.6. Сүүлийн жилүүдэд буюу 2019, 2020, 2021, 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалтыг хүснэгтээр ирүүлэх бөгөөд төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй 1-ээс доошгүй ажил хийж гүйцэтгэсэн байна. Сүүлийн жилүүдэд (2019, 2020, 2021, 2022 он)-д гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээ, акт, захиалагчийн тодорхойлолтыг хавсаргана.
4. Монгол Улсын эсвэл үүсгэн байгуулагдсан улсын (гадаадын хуулийн этгээдийн хувьд) хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө мэдүүлэг хүлээн авах эцсийн өдрийн байдлаар

бүрэн төлсөн байна. Мөн дараах тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба дэлгэрэнгүй санал хүлээн авах эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. Үүнд:

- 4.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт (гадаадын хуулийн этгээдийн хувьд ижил төстэй тодорхойлолт байх)
 - 4.2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивын тодорхойлолт (гадаадын хуулийн этгээдийн хувьд ижил төстэй тодорхойлолт байх)
 - 4.3. Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолт
 - 4.4. Татварын ерөнхий газрын сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг ирүүлэх бөгөөд 36 оронтой нууц дугаар гаргацтай байх (гадаадын хуулийн этгээдийн хувьд ижил төстэй тодорхойлолт байх)
 - 4.5. Төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машинаас нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт (гадаадын хуулийн этгээдийн хувьд ижил төстэй тодорхойлолт байх)
5. Гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх эрхтэй.
 6. Мэдүүлгийг Монгол хэл дээр ирүүлнэ. Гадаадын хуулийн этгээдийн хувьд Англи хэл дээр ирүүлж болох бөгөөд Монгол хэл дээрх орчуулгыг давхар ирүүлнэ.
 7. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
 8. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 10:00 цагаас 10 дугаар сарын 20-ны өдрийн 17:00 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 11:00 цагийн дотор ирүүлнэ үү.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,

Бага тойруу 8/1, Сити тауэр 4 давхар, 403 тоот

“Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт” ХХК

Утас: 77666556

Цахим хаяг: www.tender.gov.mn